



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/407

Есөнбулаг

Г Техникийн комисс томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Баянхайрхан баг, Солонго хорооллын нутаг дэвсгэрт хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 50 айлын орон сууцны барилга байгууламжийг ашиглалтад оруулахад урьдчилсан дүгнэлт гаргах үүрэг бүхий техникийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Д.Гаадамба (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүдэд: Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

Б.Батбилэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)

Д.Содномдаржаа ("Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-ын инженер)

Б.Бээжин ("Алтай-Улиастайн Эрчим Хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)

Г.Хүрэлхүү ("Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер)

Д.Цэвэлмаа ("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер)

Г.Цэлмэгтуяа ("Солонго дулааны станц" ААТҮГ-ын ерөнхий инженер)

Б.Батбаяр ("Барилга байгууламж" ХХК-ийн инженер) (зохиогч)

2.

Б.Энхболд

("Саусгоби брэндс" ХХК-ийн ерөнхий инженер)

Нарийн бичгийн дарга: Д.Мягмарсүрэн ("Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-ын инженер)

2.Техникийн комисс нь Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоолын хавсралтын 6.1, 6.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж, үр дүнг 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Д.Гаадамба)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

